

Эрүүл мэндийн тогтолцооны урт хугацааны шинэчлэлд хямралын үеийн арга хэмжээ тустай болох нь



Монгол Улсад иргэдийн халааснаас гарах эрүүл мэндийн зардалд оношилгооны зардал багтсан байдаг. Зургийн АХБ.

Санхүүгийн хямралын үед эмчилгээний зардалд татаас олгох хөтөлбөр хэрэгжүүлсэн нь Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцоог илүү бат бөх болгох боломжийг бүрдүүлжээ.

Удиртгал

2007-2008 оны дэлхийн санхүүгийн хямрал Монгол Улсын эдийн засагт томоохон цохилт болсон. Эдийн засгийн өсөлт буурахын зэрэгцээ ядуурлын түвшин нэмэгдсэн нь тус улсын олон өрхийг хүнд байдалд оруулсан юм. Засгийн газар төсвийн алдагдлыг бууруулах хэмнэлтийн горимд шилжсэнээр нийгмийн хамгаалал, халамжийн төсвийг ч танахад хүрсэн. Үүний уршгаар эмнэлгийн тусламж, үйлчилгээнд зарцуулах зардал багасч, нийт иргэд, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүд зэрэг нийгмийн эмзэг, ядуу бүлгийн иргэдийн эрүүл мэндэд урт хугацаандаа сөрөг нөлөө үзүүлсэн юм. Хэдийгээр Монгол Улсад эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг голлон улсын төсвөөс, харин эмнэлгийн үйлчилгээг эрүүл мэндийн даатгалаас түлхүү санхүүжүүлдэг боловч иргэд хувиасаа өндөр зардал гаргах шаардлагатай тулгарсаар байдаг. Эдгээр зардалд төр, иргэн хувааж төлдөг зардал болох эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх зардал, оношилгоо үйлчилгээний зардал, төрөөс олгох ямар нэг татаас байхгүй атлаа эрүүл мэндийн даатгалд мөн хамрагддаггүй эмнэлгийн протез болон бусад хэрэгсэл, эмийн зардал зэрэг ордог байна.

Эдийн засгийн хямралын үед ядуу иргэдэд эрүүл мэндийн нэн шаардлагатай үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэх зорилгоор “[Санхүүгийн хямралын үед ядуу иргэдийн эрүүл мэндийг хамгаалах төсөл](#)”-ийг 2009 онд Монголд хэрэгжүүлж эхэлжээ. Тус төслийг Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны хариуцан удирддаг Ядуурлыг бууруулах Японы сангийн гурван сая ам.долларын санхүүжилтээр хэрэгжүүлсэн юм. Төслийн хүрээнд хямралын эсрэг арга хэмжээ, түүний дотор “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрхийн бичиг” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэ нь Монгол Улсын эрүүл мэндийн салбарт нийгмийн хамгийн эмзэг бүлэгт, тэр дундаа ядуу болон орон гэргүй иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй болгохыг зорьсон, тодорхой зорилтот бүлэгт чиглэсэн анхны хөтөлбөр болсон юм. Монголд хэрэгжүүлсэн хямралын эсрэг богино хугацааны арга хэмжээ нь эрүүл мэндийн тогтолцоог урт хугацаанд бат бөх болгоход чухал ач холбогдолтой байсан төдийгүй бусад орнуудад сургамж болж байна.

Энэхүү кейс судалгааг “[Санхүүгийн хямралын үед ядуу иргэдэд хүргэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг баталгаажуулсан нь: Монгол Улсад хэрэгжсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрхийн бичиг хөтөлбөр](#)” техникийн цуврал тайланд үндэслэн боловсруулсан болно.

Хямралын үеийн арга хэмжээ: “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрхийн бичиг” хөтөлбөрийн туршлага

Монгол Улсад 2011-2013 онд хэрэгжүүлсэн “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрхийн бичиг” (цаашид Эрүүл мэндийн эрхийн бичиг хөтөлбөр гэх) хөтөлбөрийг үндэсний болон орон нутгийн түвшний оролцогч талуудтай өргөн хүрээнд зөвлөлдсөний үндсэн дээр боловсруулжээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхан шатны эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг хамруулахын зэрэгцээ хэрэгжилтийг хангах чадавхийг бэхжүүлэх шаардлагатай байв. Эрүүл мэндийн эрхийн бичиг хөтөлбөрт хамрагдах эрх бүхий өрхүүдийг дараах үйлчилгээнд үнэ төлбөргүй хамруулсан. Үүнд: (i) аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт үзүүлэх, оношлуулах болон хэвтэн эмчлүүлэх зэрэг лавлагаа шатлалын эмнэлгийн үйлчилгээ; (ii) өрх/сумын эмчийн жороор олгох эм; болон (iii) сумаас аймаг хүрэх унааны зардал тус тус хамаарна.^[1] Тус хөтөлбөр нь Монгол Улсын 21 аймгийн 329 сум, нийслэлийн есөн дүүргийг хамран үндэсний хэмжээнд хэрэгжсэн. Хөтөлбөрт хүн амын хамгийн ядуу таван хувь болох 95,501 иргэнийг оруулаад нийт 250,000 орчим хүн хамрагджээ.

Хямралын эсрэг авах арга хэмжээтэй холбоотой бий болох дараах боломж, үр нөлөөг эрүүл мэндийн эрхийн бичиг хөтөлбөрөөс онцолжээ.

Хямралын эсрэг арга хэмжээ нь эрүүл мэндийн бусад хөтөлбөрүүдийг илүү үр дүнтэй болгох инновацид чиглэх нь. Эрүүл мэндийн эрхийн бичиг хөтөлбөрт

хамрагдах зорилтот өрхүүдийг оновчтой тогтоох зорилгоор орлогыг орлуулан тооцох аргачлал (ООТА)-ыг нэвтрүүлсэн. ООТА-аар хийсэн судалгаа нь хэрэгцээнд суурилсан байсан тул өрхийн оршин суугаа байршил, орон гэрийн чанар, эзэмшиж буй эд хогшил, өрхийн хүн ам зүйн үзүүлэлт, боловсролын түвшин, насанд хүрсэн гишүүдийн эрхэлж буй ажил зэрэг бодитоор тогтоох боломжтой энгийн үзүүлэлтүүдийг ашиглажээ. Энэ нь нийгмийн халамжийн зорилтот бүлгийг хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн, өндөр настан эсхүл хүүхэд зэргээр бүлэглэн, орлого тооцохгүйгээр ангилж тогтоох аргаас эрс ялгаатай байсан. ООТА-ыг нэвтрүүлсэн нь ирээдүйд хэрэгжих нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд хамрагдах зорилтот хүн амын эрх бүхий иргэдийг оновчтой тогтооход нэн ач холбогдолтой байв. Төслийн хүрээнд бүрдсэн орлого багатай өрхийн салбар дундын мэдээллийн санг Засгийн газрын бусад хөтөлбөрүүдэд ашиглуулах зорилгоор холбогдох төрийн байгууллагуудад нээлттэй болгож өгсөн байна.

Хямралын эсрэг арга хэмжээ нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний доголдлыг олж тогтооход хувь нэмэр оруулах нь. Эрүүл мэндийн эрхийн бичиг хөтөлбөрийн хүрээнд нэмэлт тусламж, үйлчилгээ шаардлагатай бага орлоготой өрхүүдийн хэрэгцээг тодруулж чадсан. Түүнчлэн, системийн үр ашиггүй, хүртээмжгүй байдал болон улсын эмнэлгүүдэд байдаггүй эрүүл мэндийн үйлчилгээнүүд зэрэг эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжтэй холбоотой асуудлуудыг хөндсөн. Тус хөтөлбөр нь эрүүл мэндийн үйлчилгээний цоорхойг арилгахад чиглэхийн зэрэгцээ зайлшгүй шаардлагатай эмийн зардлыг төрөөс татаасжуулах нь иргэдийн халааснаас гарах төлбөрөөс ядуусыг хамгаалах гол арга болохыг батлан харуулсан анхны хөтөлбөр байв. Эрүүл мэндийн эрхийн бичиг хөтөлбөр нь төрийн эрүүл мэнд, нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд ядуу болон орон гэргүй иргэдийг хамруулахад чиглэсэн хууль, эрх зүйн орчинг сайжруулахад тодорхой хувь нэмэр оруулсан юм.

Хямралын эсрэг арга хэмжээний үр дүнд эрүүл мэндийн системийг бүхэлд нь оновчтой болгоход чиглэсэн хурдан, прагматик шийдлүүд бий болох нь. Цаг хугацаа, хөрөнгө нөөц зарцуулан байж шинэ бүтэц бий болгохын оронд нэгэнт байгаа бүтэц, зохион байгуулалт дээр түшиглэн хэрэгжүүлэх шийдлээр эрүүл мэндийн эрхийн бичиг хөтөлбөрийг боловсруулсан. Энэхүү прагматик хандлага нь хөтөлбөрийн хэрэгжилтийг хялбаршуулаад зогсохгүй одоо байгаа тогтолцоог улам бэхжүүлэх зорилготой байлаа. Өрх, сумын эмч нарыг хөтөлбөрийн тусламж үйлчилгээг хүргэх эхний цэг болгон оролцуулснаар өрхийн болон сумын эрүүл мэндийн төвийн хаалга баригчийн үүргийг улам баталгаажуулсан байна. Түүнчлэн Эрүүл мэндийн эрхийн бичиг хөтөлбөрийн дэвтрээс өөр ямар нэгэн нэмэлт маягт, шат дамжлага бий болголгүйгээр сум, өрхийн эрүүл мэндийн төв болон аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг хоорондын шилжүүлгийн тогтолцоог ашигласан байна. Хөтөлбөрт хамрагдсан иргэд мөнгөнд санаа зоволгүйгээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авах боломжтой болсон бол тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд гаргасан зардлаа хялбар замаар, баталгаатай нөхөн авах боломжтой байв.

Хямралын эсрэг арга хэмжээ нь төрийн албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх боломж болох нь. Эрүүл мэндийн эрхийн бичиг хөтөлбөрийн хэрэгжилт, зохион байгуулалт болон эрх бүхий өрхүүдийг хөтөлбөрт хамруулах журам зэргийг тайлбарлан таниулах сургалтыг орон нутгийн нийгмийн ажилтнуудад зориулан зохион байгуулсан. Түүнчлэн, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд болон нэхэмжлэлийг хянах, төлбөрийг шилжүүлэх асуудлыг хариуцсан нийгмийн даатгалын байцаагч нарыг зохих сургалтанд хамруулсан байна.

Сургамж:

Эрүүл мэндийн эрхийн бичиг хөтөлбөр нь эрүүл мэндийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар санхүүгийн хямралын үед нэн ядуу иргэдээ хамгаалах Засгийн газрын зорилтод үнэтэй хувь нэмэр оруулсан. Түүнчлэн, эрүүл мэндийн салбарыг илүү бат бөх болгоход салбар хоорондын уялдаа холбоо хир чухал болохыг тус хөтөлбөр батлан харуулсны зэрэгцээ оролцогч талуудын хамтын ажиллагааг хэрхэн бэхжүүлэхийг тодорхойлж өгсөн.

Хямралын эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь, санхүүгийн хямралын үед ч, эсвэл коронавируст цар тахал гэх мэт эрүүл мэндийн онцгой байдлын үед ч, нийгмийн хамгийн эмзэг бүлгийнхэнд шууд ашиг тусаа өгөхөд чиглэгддэг бөгөөд эрүүл мэндийн тогтолцоо болон бусад хөтөлбөрийг урт хугацаандаа сайжруулахад түлхэц болдог. Эрүүл мэндийн эрхийн бичиг хөтөлбөрийн туршлага, үр дүн нь хямрал дууссаны дараа ч эрүүл мэндийн салбарын шинэчлэл, тогтолцооны хөгжилд түлхэц, дэмжлэг үзүүлсээр ирсэн юм.

^[1] 2012 оны 11-р сард үйлчилгээний багцад аймаг, сум хоорондын хоёр талын замын зардлыг нэмж оруулсан болно.

Эх сурвалж

Ж.Алтантуяа. 2016 он. [Санхүүгийн хямралын үед ядуу иргэдэд хүргэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг баталгаажуулсан нь: Монгол Улсад хэрэгжсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрхийн бичиг хөтөлбөр](#). АХБ-ны Зүүн Азийн газраас эрхлэн гаргадаг цуврал тайлан №8. Манила: Азийн Хөгжлийн Банк.

Азийн Хөгжлийн Банк. [Монгол Улс: Санхүүгийн хямралын үед ядуу иргэдийн эрүүл мэндийг хамгаалах төсөл](#).

АХБ. [Нийгмийн хамгааллын төслийн товч танилцуулга: Монгол Улсад санхүүгийн хямралын үед ядуу иргэдийн эрүүл мэндийг хамгаалах төсөл](#).